

ХУРАЛДААНЫ ТОЙМ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ХОРИН ДОЛДУГААР ХУРАЛДААН

Хуралдаан 2015 оны есдүгээр сарын 10-ны 14 цаг 00 минутад эхэлж, 14 цаг 18 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 18 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Хүний Эрхийн Үндэсний Комиссын Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “а”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Чойжоогийн Алтангэрэлийг Хүний эрхийн үндэсний комиссын Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, тус комиссын Ажлын албаны дарга А.Дашдэлэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан харилцаа, холбооны газрын Мэдээллийн технологийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлах тухай	<p>Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын дарга Ц.Жадамбаагийн 2015 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 1/771 тоот албан бичгээр Засгийн газрын тохируулагч агентлаг Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газрын Мэдээллийн технологийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалт зарлуулах захиалга ирсүүлснийг хэлэлцээд, 2015 оны 9</p>

		<p>дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулахаар шийдвэрлэлээ.</p>
3	<p>Зарим хүмүүсийг "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах тухай</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 3.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд гаргасан шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Төрийн албаны чиг үүрэг, албан үүргээ үнэнч шударга, идэвх санаачлагатай, үр бүтээлтэй гүйцэтгэж, тогтвортой амжилт гарган төрийн албаны үйл хэрэгт бодитой хувь нэмэр оруулсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 421 дүгээр ангийн ахмад настан, бэлтгэл дэд хурандаа Цэвээний Манийхаан, бэлтгэл хурандаа Хөхөөгийн Уламбаяр нарын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Хорих 421 дүгээр анги байгуулагдсаны 50 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын "Төрийн албаны тэргүүний ажилтан" тэмдгээр шагнах.</p> <p>2. Шагнагдсан хүн тус бүрийн тэмдгийг дагалдах мөнгөн шагнал (хоёр зуун мянган төгрөг)-ыг Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 71 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны тэргүүний ажилтан тэмдгээр шагнах журам"-ын 4.2-т заасны дагуу шагнагдагсдад тухайн байгууллагаас олгох.</p> <p>3. Шагнагдсан төрийн албан хаагчдад баяр хүргэж, ажлын амжилт хүсэх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

